

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Чойр хот

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх үр дүн	Биелэлт
1	2	3	4	5
1	Газрын Ёс зүйн дэд хорооны 2024 онд ажиллах төлөвлөгөөг гарган батлуулах	I улирал	Ажлын төлөвлөгөө батлагдан хэрэгжсэн байна	Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хурлаар 2024 онд ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлав.
2	Газрын дэргэдэх Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн газрын даргаар батлуулах	III улирал	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны дүрэмд заасны дагуу хорооны бүрэлдэхүүн бүрэлдэн үйл ажиллагаа эхэлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын чиглэлийн дагуу байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог 2023 онд байгуулан ажиллуулж 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/32 дугаар тушаалаар бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан Ёс зүйн дэд хорооны даргаар Нийгмийн хамгаалалын хяналтын улсын байцаагч Б. Аюушжав, гишүүдээр Сангийн мэргэжилтэн Б. Мөнхцэцэг, Архив, бичиг хэрэг, хөрөнгө хариуцсан мэргэжилтэн Б. Жавзан нарын 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилж томилогдсон хорооны дарга гишүүд ажлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.
3	Ёс зүйн зөрчил гарсан тухай бүр Ёс зүйн дэд хорооны хурлыг зохион байгуулж, шийдвэрийг газрын удирдлагад хүргүүлэх	Тухай бүрт	Ёс зүйн дэд хороо холбогдох хууль, дүрэм, журам дэгийн дагуу хуралдаж үр дүн гарсан байх.	2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан болон байгууллага иргэдээс гомдол, мэдээлэл ирээгүй байна.
4	Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохиогдож буй Ёс зүйн	Тухай бүрт	Газрын нийт ажилтан, албан хаагчид сургалтад хамрагдсан байна.	Байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2024 онд ажиллах ажлын төлөвлөгөөний дагуу ажилтан албан хаагчдад Говьсүмбэр аймаг дахь Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь ажилтнаас "Хүний эрх хамгааоогчийг хамгаалах

	сургалтад ажилтнуудыг хамруулах			механизмын үйл ажиллагаа, Хүн худалдаалах гэмт хэрэг гэж юу вэ," аймгийн Хууль эрх зүйн хэлтсийн дарга Нэргүйцэцэг "Авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", аймгийн хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга М.Анхбаяр "Манлайлах ур чадвар" Тагнуулын газрын ажилтан Б.Лувсанчоглон "Төрийн болон албаны нууцын тухай хууль" сэдвүүдээр танхимын сургалтыг 4 удаагийн 10 цагийн сургалтыг зохион байгуулсан. Мөн Төрийн албаны төв зөвлөлийн ахлах референт Э.Мөнхгэрэл, Идэрчулуун нарын зохион байгуулсан "Төрийн албаны шинэтгэл, Ёс зүйт төрийн албан хаагч" сэдэвт сургалтууд, Төрийн албаны "7:4:10" сургалтад сэдвээс шалтгаалан ажилтнуудыг хамруулж байна.
5	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг ажилтнуудад танилцуулах	III улирал	Газрын нийт ажилтан, албан хаагчид сургалтад хамрагдсан байна.	Улсын Их хурлын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг газрын нийт албан хаагчдад 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн газрын ажилтнуудын хуралдаанд танилцуулан ярилцлага зохион байгууллаа.
6	Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилэн сэргийлэх нь сургалт зохион байгуулах	IV улирал	Газрын нийт ажилтан, албан хаагчид сургалтад хамрагдсан байна.	2024 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Аймгийн Прокурорын газрын хяналтын прокурор А.Аварзэд "Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль"-уудыг хэрэглэх ашиг сонирхолын зөрчлөөс хэрхэн зайлс хийх 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Аймгийн хууль эрх зүйн хэлтийн дарга Нэргүйцэцэг "Авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, талаар сургалт зохион байгуулсан.
7	Хүнд суртал, ажлын байранд архидан согтуурах, иргэдэд хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр	IV улирал	Иргэд даатгуулагчид хөнгөн шуурхай чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлсэн байна	Аймгийн цагдаагийн хэлтсийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн дарга, цагдаагийн хошууч Ч.Жавхлан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль"-аар 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулан ажилласан.

	ажилтнуудад сургалт зохион байгуулах			
8	Ажилтан албан хаагчдын харилцаа хандлага, зан төлөвийн сорил, үр дүнд дүгнэлт хийх	IV улирал	Ажилтнуудын зан харилцаа сайжирсан байна	Аймгийн цагдаагийн хэлтсийн сэтгэл зүйч цагдаагийн ахмад н. Наранцэцэг Харилцаа хандлага, зан төлвийн байдлын талаарх сургалтыг нийт ажилтан, албан хаагчдыг хамруулан зохион байгууллаа. Эхний ээлжинд төрийн захиргааны албан хаагчдыг хамруулсан зан төлвийн тестийг сэтгэл зүйчээр хийлгэж дүгнэлт гарган байгууллагын удирдлагад танилцууллаа.
9	Шинээр томилогдсон албан хаагчдад Нийгмийн даатгалын байцаагч, ажилтны ёс зүйн дүрмийн талаар танилцуулах	Улирал бүр	Шинээр томилогдсон ажилтнуудыг бүрэн хамруулсан байна	Нийт болон шинээр томилогдож байгаа ажилтнуудад “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”, “Үйлчилгээний стандарт, Нийгмийн даатгалын тухай хууль, эрх зүйн” талаар дотоод сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсан.
10	Ёс зүйн дэд хорооны самбарыг нээх	IV улирал	Ажилтан, албан хаагчид ёс зүй, соён гэгээрлийн талаар мэдлэг авсан байна.	Байгууллагын ёс зүйн хорооны мэдээллийн самбарыг газрын үйлчилгээний зааланд байршуулан цаг үеийн блон холбогдох хууль, журмыг байрлуулан сурталчлан ажиллаж байна.
11	Ёс зүйн дэд хорооны ажлын тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэх.	Хагас, бүтэн жил	Зохион байгуулсан ажлын тайланг хагас бүтэн жилээр хугацаандаа Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн хороонд хүргүүлсэн байна.	Тайланг хагас, бүтэн жилээр гаргаж хугацаанд нь хүргүүлнэ.

ТАЙЛАН БИЧСЭН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ЖАВЗАН

ХЯНАСАН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

Б.АЮУШЖАВ